

**ТӨР-ИРГЭНИЙ ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТУХАЙ
/ТӨРИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТУХАЙ ХУУЛИЙН
ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА/ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

Нэг.Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага

1.1.Хуулийн төсөл боловсруулах хууль зүйн үндэслэл, шаардлага

Монгол Улсын Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 4 дэх хэсэгт “Төр нь үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, аж ахуйн бүх хэвшлийн болон хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн эдийн засгийг зохицуулна.” гэж, Арван зургадугаар зүйлд “Монгол Улсын иргэн дараах эрх, эрх чөлөөг баталгаатай эдэлнэ” гээд тус зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалтад “эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй.” гэж, 4 дэх заалтад “...Аж ахуй эрхлэх эрхтэй” гэж, 7 дахь заалтад “сурч боловсрох эрхтэй.” гэж, 12 дахь заалтад “төрийн байгууллага, албан тушаалтанд өргөдөл, гомдлоо гаргаж шийдвэрлүүлэх эрхтэй. Төрийн байгууллага, албан тушаалтан нь иргэдийн өргөдөл, гомдлыг хуулийн дагуу шийдвэрлэх үүрэгтэй” гэж, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна” гэж, мөн зүйлийн 3 дахь хэсэгт “Хүн эрх, эрх чөлөөгөө эдлэхдээ үндэсний аюулгүй байдал, бусад хүний эрх, эрх чөлөөг хохироож, нийгмийн хэв журмыг гажуудуулж болохгүй” гэж тус тус заасан.

Түүнчлэн, Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын Зорилт 2.5-д “Амьдралын хэрэгцээг хангасан эрүүл, ая тухтай, таатай орчныг бүрдүүлж баталгаат хүнсээр хангана.” гэж, Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.3.4.26-д “Хүнсний аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ, тандалт судалгаанд олон улсын стандартад нийцсэн арга зүйг нэвтрүүлэн, хүнсний аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээг сайжруулна.” гэж тус тус тусгажээ.

Мөн Улсын Их Хурлын 2025 оны “Засгийн газарт чиглэл өгөх тухай” 114 дүгээр тогтоолын 1.1-д иргэн, аж ахуйн нэгжид зөвлөн туслах, урьдчилан сэргийлэх, үйл ажиллагаанд мэргэжлийн туслалцаа үзүүлэх нөхцөлийг бүрдүүлэх, төрийн хяналтын хүрээг оновчилж, хүнс, эрүүл ахуй, эм, эмчилгээний чанар, уул уурхай, газрын тос, байгаль орчин, дэд бүтэц, боловсрол зэрэг нийтийн эрх, хууль ёсны ашиг сонирхол, иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх хөндөгдөх, эсхүл зөрчигдөх эрсдэлтэй үйл ажиллагаанд хяналт тавих төрийн хяналт шалгалтын зарчмыг олон улсын жишигт нийцүүлэн шинэчлэх хүрээнд Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж Улсын Их

Хуралд өргөн мэдүүлэхийг Засгийн газарт даалгасан.

Төрийн хяналт шалгалтыг хэрэгжүүлэхтэй холбоотой харилцааг бие даасан хуулиар зохицуулахаар 1995 онд Төрийн хяналт шалгалтын тухай анхдагч хуулийг батлан мөрдүүлсэн бол 2003 онд тус хуулийг шинэчлэн баталжээ.

Төрийн хяналт шалгалтын тухай хууль хэрэгжсэнээс хойш 12 удаа нэмэлт, өөрчлөлт орсон байна.

Өөрөөр хэлбэл, эдгээр нэмэлт, өөрчлөлт нь төрийн хяналт шалгалтын ажиллагаатай холбоотой тулгараад байгаа бэрхшээлтэй асуудлыг шийдвэрлэхээс илүүтэй салбарын бусад хуулиудын шинэчлэл, эсхүл тэдгээрт нэмэлт, өөрчлөлт орсонтой холбоотой байна.

2015 онд Монгол Улсын Их Хурлаас Захиргааны хариуцлагын тухай хууль болон нийгмийн тодорхой төрлийн харилцааг зохицуулж буй 220 гаруй хуулиар тогтоосон зөрчил, түүнд хүлээлгэх хариуцлагыг тодорхойлсон хэм хэмжээг төрөлжүүлэн нэгтгэсэн⁶ Зөрчлийн тухай хуулийг, 2017 онд зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг төрийн хяналт шалгалтын ажиллагаанаас ялган зохицуулах зорилгоор Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийг тус тус батлан мөрдүүлсэн.

Гэвч Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн зохицуулалт эрх зүйн зохицуулалтын шинэчлэлээс хоцорсон төдийгүй энэ төрлийн харилцааны үндсэн зарчим, аргачлалыг тодорхойлох боломжгүй, зохицуулалтын хувьд бусад хуулиудтай уялдаа хангагдахгүй байна.

Иймд Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн шинэчилэн найруулж, Төр-Иргэний хяналт шалгалтын тухай хуулийн төслийг боловсруулах хууль зүйн хэрэгцээ, шаардлага үүсээд байна.

1.2.Хуулийн төсөл боловсруулах практик хэрэгцээ, шаардлага

2003 онд төрийн хяналт шалгалтыг хэрэгжүүлэх нэгдсэн тогтолцоотой болсноор Мэргэжлийн Хяналтын Ерөнхий газар бий болж, хяналтын хүрээнд 112 хууль, 3600 гаруй дүрэм, журам, 4500 гаруй стандартын хэрэгжилтэд хяналт тавьж ажилладаг байсан. Төрийн хяналтын тогтолцоог Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 469 дүгээр тогтоолоор Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын чиг үүргийг салбарын яамдын бүтцэд шилжүүлснээр хяналт шалгалтын нийт 31 чиглэлийг 11 яам, 2 агентлаг, орон нутгийн захиргааны байгууллага хариуцан хэрэгжүүлэн ажиллаж байна.

Хяналт шалгалтын төвлөрсөн тогтолцоо салбаруудад шилжиж, хяналт шалгалтын нэгдсэн удирдлага үгүй болсноор хяналт шалгалт давхардсан, иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх хангагдахгүй байх зэрэг дараах хүндрэл,

бэрхшээлүүд үүсээд байна.

-Хяналт шалгалтын нэгдсэн тогтолцоотой байх үе буюу 2021 онд 9,920 төлөвлөгөөт хяналт шалгалтыг төлөвлөж, үүнээс 6,319-г буюу төлөвлөгөөний 63%-г хийж гүйцэтгэж байсан бол 2025 онд 10,102 объектын 5,536-д буюу 54%-г төлөвлөгөөт хяналт шалгалтыг хийсэн байна. Үүнээс үзэхэд эрсдэлд тулгуурлан төлөвлөсөн шалгалтын тоо буурч, харин төлөвлөгөөт бус хяналт шалгалтын тоо, Зөрчлийн тухай хуулийн дагуу акт, торгууль ногдуулсан шийдвэрийн тоо нэг дахин нэмэгдсэн нь эрсдэлийг бууруулахад чиглэсэн цогц, урьдчилан сэргийлэх арга хэмжээ хийгдэхгүй байгааг илэрхийлж байна.

-Төрийн хяналт шалгалтыг салбар бүр өөрийн хариуцсан чиг үүргийн хүрээнд хэрэгжүүлж ирсэн нь нэг субъектэд олон байгууллага давхардуулсан хяналт шалгалт хийх, шалгалтын зорилго, аргачлал ялгаатай байх, иргэн, аж ахуйн нэгжид дарамт учруулах нөхцөлийг бүрдүүлжээ. Тухайлбал, 2024 онд “Мэдээлэл холбооны сүлжээ” ХХК-д 37, “Монгол Шуудан” ХК-д 24, “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-т 33, “Сентрал Экспресс Си Эс” ХК-д 42 удаагийн хяналт шалгалт хийгджээ.

-Төрийн хяналт шалгалтын хүрээнд зөвлөн туслах, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авдаггүй, торгох, албан шаардлага тавих хэлбэр давамгайлж байна. Ерөнхий сайдын 2024 оны 01 албан даалгаврын хүрээнд байгуулагдсан Хяналт шалгалтын давхардлыг судлах, шалтгаан нөхцөлийг арилгах чиг үүрэг бүхий ажлын хэсгийн ажлын хүрээнд түүврийн аргаар асуулгын судалгаа явуулсан бөгөөд судалгаанд оролцсон байгууллагын 70 гаруй хувьд нь хяналт шалгалтын мөрөөр арга хэмжээ тооцсон бөгөөд соён гэгээрүүлэх, мэргэжлийн зөвлөгөө үзүүлэх үйл ажиллагаа үндсэндээ хийгдээгүй байна.

-Хүнсний аюулгүй байдал, эмийн чанар, хүрээлэн буй орчны аюулгүй байдлын хяналтыг хэд хэдэн байгууллагад хариуцан өөр өөр агуулгаар дүгнэлт гаргадаг, нэгдсэн мэдээллийн системгүй хяналт шалгалт нь үр ашиггүй, олон улсын сайн туршлагад нийцэхгүй байна.

-Сүүлийн 6 жилд үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын 2871 тохиолдолд нийт 3031 хүн өртсөн байна. Үүнээс 2831 нь үйлдвэрлэлийн ослын, 40 нь хурц хордлого байгаагаас осол, хурц хордлогын тоо 2022 онд 395 бол 2025 онд 747 болсон байна. Хяналт шалгалтын нэгдсэн тогтолцоотой байх үеэс ойролцоогоор нэг дахин өссөн үзүүлэлттэй байна.

-Мөн төрийн хяналт шалгалт нь урьдчилан сэргийлэх, зөвлөн туслах чиг үүргээсээ илүүтэй зөрчил илрүүлэх, шийтгэл оногдуулахад чиглэсэн байдал давамгайлж байна.

Үүнтэй холбоотойгоор төрийн хяналт шалгалт болон зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны зааг тодорхой бус, эрх зүйн зохицуулалт хоорондоо давхцах, хийдэл үүсэх нөхцөл бүрдсэн тул эдгээр ажиллагааг хууль зүйн хувьд тодорхой зааглан ялгах, уялдуулах шаардлага тулгарч байна.

Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн үнэлгээгээр /2021он/ “Хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний судалгааны дүгнэлтэд тусгагдсан хяналт шалгалтын тогтолцоо, ангилал, төрөл, хэлбэр, түүнийг хэрэгжүүлэх нийтлэг үндэслэл, журам, нэр томьёоны агуулгын талаарх давхардал, хийдэл, тодорхой бус зохицуулалт, хууль хоорондын зөрчлийг арилгах, мэргэжлийн хяналтын байгууллага, улсын байцаагчийн бүрэн эрх, чиг үүргийг боловсронгуй болгож, шалгуулагч этгээдийн эрх, үүргийг баталгаажуулж, төрийн хяналт шалгалтын үр нөлөөг сайжруулах чиглэлээр Төрийн хяналт шалгалтын тухай хуулийг шинэчлэн найруулах шаардлагатай байна. Хяналт шалгалтын “тандалт судалгаа”, “зөвлөн туслах”, “хяналт шинжилгээ”, “урьдчилан сэргийлэх шалгалт” зэрэг шинэлэг төрөл хэлбэрүүдийг болон улсын байцаагчийн хяналт шалгалттай холбоотой үйл ажиллагааны стандартыг байгууллагын журмаар тогтоон хэрэгжүүлж байгааг хуульчлах нь зүйтэй.” хэмээн дүгнэсэн байна.

Иймд үүсээд буй практик хэрэгцээ, шаардлагыг үндэслэн олон улсын сайн туршлага, эрх зүйн шинэчлэлтэй уялдуулах зорилгоор Төр-Иргэний хяналт шалгалтын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төслийг боловсруулна.

Хоёр.Хуулийн төслийн ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Төр-Иргэний хяналт шалгалтын тухай /Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн шинэчилсэн найруулга/ хуулийн төслийг дараах агуулгаар боловсруулна:

1.Хуулийн төсөлд хүн, хуулийн этгээдийн ашгийн болон ашгийн бус үйл ажиллагааны улмаас хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах, хөдөлмөрлөх, сурч, боловсрох эрх зөрчигдсөн эсэх, эсхүл зөрчигдөх эрсдэл үүсэж байгаа эсэхэд төр, төр-иргэний хяналт тавьж, нийтийн эрх, ашиг сонирхолыг хамгаалахаар чиглүүлэн тодорхойлж, төрийн хяналт шалгалтыг эрсдэлийн үнэлгээнд суурилсан, зөвлөн туслах, урьдчилан сэргийлэх зарчимд тулгуурлан хэрэгжүүлэхээр тусгана.

2.Хуулийн нэр томьёоны тодорхойлолтыг шинээр томьёолон, хяналт шалгалт, шалгалтын хоорондын зааг ялгаа, эрсдэлд суурилсан шинжилгээт шалгалт, хяналт шалгалтыг хэрэгжүүлэх байгууллагыг тодорхойлно.

3.Төрийн хяналт шалгалтын төрөл, түүнийг хэрэгжүүлэх арга, хэлбэр, хяналтыг хэрэгжүүлэх нийтлэг үндэслэл, журмыг тогтооно.

4.Эрсдэлд суурилсан хяналт шалгалтын тогтолцоог бий болгоно.

Улсын байцаагч нь хяналт шалгалтын удирдамжийн хүрээнд батлагдсан хяналтын хуудасны дагуу тухайн үйлдвэрлэл, үйлчилгээ, объектын эрсдэлийг үнэлж, үүнтэй уялдуулан холбогдох шийдвэрийг гаргахаар тусгана. Ингэснээр хүн, хуулийн этгээд нь өөрийн эрсдэлийн үнэлгээнд суурилсан шийдвэрийн хүрээнд холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэн болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх нөхцөл бүрдэнэ.

5.Нэгдсэн тогтолцоо, төвлөрсөн удирдлагатай хяналт шалгалтын тогтолцоог бий болгож, хяналт шалгалтын иж бүрэн, цогц арга хэмжээг хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлж хуульчилна. Энэ хүрээнд нэгдсэн шинжилгээт шалгалтыг хэрэгжүүлэх Үндэсний лавлагаа лабораторийг нэгдсэн тогтолцоонд хамааруулж, эрх зүйн үндсийг тодорхой болгоно. Түүнчлэн, зарим чиглэлийн хяналт шалгалтыг мэргэжлийн холбоо, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлж болохоор тусгана.

6.Хүн, хуулийн этгээдийг шалгах хүрээ, хязгаарыг тодорхой болгож, шалгуулах болсон үндэслэл, шалтгааныг мэдэх боломжийг тусгана.

7.Төр ямар үед хяналт шалгалтыг зохион байгуулах талаар тодорхой тусгана. Тухайлбал, хэрэглэгчийн үнэлгээнд суурилж тандан судалгаа, эрсдэлийн үнэлгээ хийх, иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, санал зэргийг үндэслэж хүний эрүүл мэнд, аюулгүй байдалд эрсдэл учирсан тохиолдолд газар дээр нь хяналт шалгалт зохион байгуулах зохицуулалтыг тусгана.

8.Хяналт шалгалтын болон зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг зааглан ялгана. Өөрөөр хэлбэл тус хуулийн зохицуулах харилцааг Зөрчлийн тухай хуультай давхардуулахгүй байхаар зохицуулна. Өөрөөр хэлбэл, тус хуулийн үйлчлэх хүрээ, хязгаар нь Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд заасан ажиллагаа эхлэхээс өмнөх үйл ажиллагаа хамаарна.

9.Хяналт шалгалтын мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээ нь үе шаттай болно. Тухайлбал, хяналтын хуудасны эрсдэлийн үнэлгээгээр бага эрсдэлтэй гэж дүгнэгдвэл зөвлөмж, дунд эрсдэлтэй гэж дүгнэгдвэл албан шаардлага, их эрсдэлтэй гэж дүгнэгдвэл Зөрчлийн тухай хуульд заасан арга хэмжээ авах зэрэг шат дараалсан арга хэмжээг авснаар хүн, хуулийн этгээдэд үйлдвэрлэл, үйлчилгээ, үйл ажиллагаагаа эрхлэн явуулахад саад бэрхшээл, дарамт үзүүлэх бус, алдаа, зөрчлийг арилгах боломж олгох нөхцөлийг бүрдүүлнэ.

10.Хяналтын байгууллагын чиг үүргийн хэрэгжилтийг сайжруулах зорилгоор үйл ажиллагааны хяналтын хэлбэрийг өргөжүүлэх, хяналт шалгалтын үйл ажиллагааны уялдаа холбоог зохицуулах зорилгоор мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлнэ. Түүнчлэн, уг мэдээллийн сангаар дамжуулан хүн, хуулийн этгээдийг мэдээллээр хангагдах боломжийг бий болгоно.

11.Төр-Иргэний хяналтын тогтолцоог бий болгох бөгөөд Олон нийтийн хяналтын зөвлөлөөр дамжуулан хэрэгжүүлнэ. Уг зөвлөл нь олон нийтийн болон хэрэглэгчийн үнэлгээний тайланг нэгтгэх, санал өгөх, үнэлгээ, судалгаа хийх, зөвлөмж боловсруулах, зөвлөн туслах үйл ажиллагааг үзүүлэх гэх зэрэг чиг үүргийг хэрэгжүүлж ажиллахаар тусгана.

Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсч болох нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар

Төр-Иргэний хяналт шалгалтын тухай /Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн шинэчилсэн найруулга/ хууль батлагдсанаар төрийн хяналт шалгалтын тогтолцоо, хяналт шалгалтыг хэрэгжүүлэх нийтлэг зарчим, үндэслэл, журам тодорхой болж, эрх зүйн зохицуулалтын хүрээнд үүсээд байгаа зөрчил, хийдэл арилж, нэгдсэн зохицуулалт, төвлөрсөн удирдлагатай болно.

Монгол Улсын Үндсэн хуулиар баталгаажуулсан иргэдийн эрх, эрх чөлөө хангагдахаас гадна төрийн үйл ажиллагааны ил тод, хариуцлагатай байх зарчим хэрэгжих боломжийг бүрдүүлэх тул хүний эрхийг хангах чиглэлд эерэг үр нөлөө үзүүлнэ. Нөгөө талаас, хяналт шалгалтын хүрээнд бизнес эрхлэгчдийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх нөхцөл бүрдэнэ.

Түүнчлэн хяналтын байгууллага, улсын байцаагчийн мэргэжлийн ур чадвар, хариуцлага нэмэгдэхээс гадна төрийн хяналт шалгалтын чиглэлээр бүртгэл, хяналтын нэгдсэн тогтолцоо бүрдэнэ.

Дөрөв.Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуультай хэрхэн уялдах талаар

Хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын нэгдэн орсон Олон улсын гэрээ болон холбогдох бусад хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулна.

Тус хуулийн төсөлтэй холбогдуулан Зөрчлийн тухай нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Автотээврийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Аялал жуулчлалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Байгаль орчныг хамгаалх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Зар сурталчилгааны тухай тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн халамжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Өрсөлдөөний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Таримал ургамлыг үр, сортын тухай тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Ургамал хамгааллын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Харилцаа холбооны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хэмжил зүйн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, түүнчлэн 2003 онд батлагдсан Төрийн хяналт шалгалтын тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг тус тус боловсруулна.

Хууль санаачлагч

---oOo---